**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 17 өдөр　　Дугаар 01/173　　Жавхлант

Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаад тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.4.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорчих хэрэгслийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсэж авто замын нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын нутаг дэвсгэрт мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг 2025 оны 10 дүгээр сарын 17-ний өдрөөс 2026 оны 04 дугаар сарын 01-нийг дуустал түр хугацаагаар хориглосугай.

2.Хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулан ард иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлэг өгч сурталчлан зарлан мэдээлж зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлж ажиллахыг хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Г.Ганбаяр), Цагдаа, дэд ахлагч (Н.Анхбаяр) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ　　Г.ЭНХЗАЯА

D:Zasag darga /zahiramj-2025/